



СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 2148

Улаанбаатар хот

Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон  
шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр 4.3, 14 дүгээр зүйлийн 14.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, Эмнэлгийн дүрмийн 4 дугаар зүйлийн 4.5,4.8.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.3.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн "Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тус журмыг мөрдөж ажиллахыг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц хөгжлийн албаны дарга (Б.Сүхтулга)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.ОЛОНБАЯР

0522031092 80017912 СС119971

Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн Захирлын  
2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн  
198 дугаар тушаалын хавсралт

## ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭН ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн /цаашид “эмнэлэг” гэх/ ажилд орох ажилтан бүрийн сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

### ХОЁР. БАРИМТЛАХ ХУУЛЬ

2.1 Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

2.2 Авлигатай тэмцэх тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зогцуулах, ашиг сонирхлоос зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн ажиллана.

### ГУРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Хүний нөөц хөгжлийн албанаас ажилтан сонгон шалгаруулах ажлын хэсгийг товлон ажиллуулна.

3.2 Ажлын хэсгийн ахлагчаар Хүний нөөц хөгжлийн албаны дарга, хүний нөөцийн менежер байна.

3.3 Эмнэлгийн үндсэн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, урт хугацааны цалингүй чөлөө авах, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд гарсан сул орон тоо, мөн шинээр бий болсон орон тоонд авч ажиллуулах иргэнд тавигдах ерөнхий шаардлагыг Эмнэлгийн захирлаар батлуулсан тухай албан тушаалын ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.

3.4 Сонгон шалгаруулалтад оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно. Нийтлэг шалгуурт тухайн шалгаруулалтад оролцогчийн ерөнхий соёл, зан харилцааны чадварыг үнэлж, тусгай шалгуурт мэргэжлийн ур чадвар, туршлага, гадаад хэлний мэдлэг зэргийг үнэлэн шалгаруулна.

3.5 Тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг Нэгдсэн эмнэлгийн удирдлагын багийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, ажлын байрны зар, тавигдах шалгуур, сонгон шалгаруулах журам, шалгаруулалтын явц, үр дүнг Нэгдсэн эмнэлгийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэнэ.

3.6 Мэргэжлийн шалгалтын асуултыг мэргэжлийн багаар урьдчилан хийлгэж, хүний нөөц хөгжлийн албанд хадгална.

3.7 Ярилцлагын шалгалтанд тухайн мэргэжлийн удирдах албан тушаалтныг заавал оролцуулж, мэргэжлийн шалгалтын дүнг танилцуулна.

## ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

### 4.1 Сонгон шалгаруулалтанд оролцогч дараах материалыг бүрдүүлнэ.

Үүнд:

- 4.1.1 Ажилд орохыг хүсэн өргөдөл
- 4.1.2 Өргөдөл гаргагчийн анкет (төрийн албан хаагчийн анкет 2022 оны А хэсэг)
- 4.1.3 Боловсролын гэрчилгээ, диплом, үнэмлэхний хуулбар
- 4.1.4 Иргэний үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар

## ТАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОГЧИЙН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ

5.1 Хүний нөөц хөгжлийн алба шалгаруулалтанд оролцогчоос материалыг хүлээн авч, огноо, цаг, минутыг тэмдэглэн оролцогчоор гарын үсэг зуруулна.

5.2 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах бүртгэлийн хугацаа дуусахад ажлын хэсэг ирсэн материалуудтай нэг бүрчлэн танилцаж, шаардлага хангасан материалуудыг бүртгэн хүн тус бүр дээр хувийн хэрэг хөтөлнө.

## ЗУРГАА СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.

6.1 Сонгон шалгаруулалтыг дараахь 3 үе шаттай явуулна. Үүнд:

- 6.1.11 дүгээр шат: Сонгон шалгаруулалтанд орохоор ажил горилогчоос ирүүлсэн материал
- 6.1.2 2 дугаар шат: Мэдлэг, ур чадварын тестын шалгалт авах (тухайн ажлын байранд тавигдах шаардлагуудыг багтаасан ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох тест, ур чадварын шалгалт авах)
- 6.1.3 3 дугаар шат: Ярилцлага хийх (тестын шалгалтанд тэнцсэн ажил горилогчтой ярилцлага хийнэ).
- 6.2 Ажлын хэсэг саналаа боловсруулан Нэгдсэн эмнэлгийн захиралд танилцуулна.

## ДОЛОО. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГ МЭДЭЭЛЭХ

7.1 Ажлын хэсэг сонгон шалгаруулалтанд оролцогчдын тэнцсэн, тэнцээгүй тухай мэдээллийг холбогдох утсаар болон цахим хаягаар сонгон шалгаруулалтын шат бүрийн дараа хүргэнэ.

7.2 Ажлын хэсгийн саналыг Хүний нөөц хөгжлийн албаны дарга Эмнэлгийн захирал 3 хоногийн дотор танилцуулна.

7.3 Ажлын хэсэг эмнэлгийн захирлын гаргасан тушаалыг холбогдох ажил горилогч танилцуулж, чиглүүлэх сургалт зохион байгуулна. (Тухайлбал: хүний нөөцийн ажилтан харъяалах тасаг, нэгжийн дарга, эрхлэгч, хамт олонд танилцуулсны дараа тасаг, нэгжийн дарга, эрхлэгч тасгийн үйл ажиллагаа, хамт олныг танилцуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу чиглүүлэх сургалтыг явуулна.

## НАЙМ .БУСАД ЗҮЙЛ

8.1 Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулсан материалыг хүний нөөцийн менежер архивт дараа оны 1 дүгээр улиралд шилжүүлнэ.

8.2 Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүний нөөц хөгжлийн алба хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шалгаруулалтын ажлын хэсэг шийдвэрлэнэ.

## ЁС. ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын бүрдүүлэлтийг бүх төрлийн эх үүсвэрийг ашиглан зохион байгуулна.

### 9.1 Дотоод эх үүсвэр

9.1.1 Өөр албан тушаалд ажиллаж буй ажилтан (Байгууллагын ажилтан өөрийн албан тушаалд сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд үр бүтээлтэй ажилласан нь нотлогдохуйц, хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд өөрийн шууд харъяалах алба/ тасгийн удирдлагын үнэлсэн үнэлгээний хуудсыг хавсарган ирүүлснээр сонгон шалгаруултад оролцох эрх үүснэ.)

9.1.2 Өөр албан тушаалд ажиллаж буй ажилтан нь сул орон тоо болон шинээр бий болсон ажлын байранд зар гарсан өдрөөс эхлэн ажлын 5 өдөрт багтаан материалаа ирүүлсэн байх;

### 9.2 Гадаад эх үүсвэр

9.2.1 Төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд

9.2.2 Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөрийн хэлтэс

9.2.3 Хүний нөөцийн бүртгэлтэй сайтуудаар дамжуулан зохион байгуулна.

3.3 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сул орон тоонд бүртгэх нээлттэй ажлын байрны зарлалд тавигдах шаардлага:

- Албан тушаалын нэр
- Үндсэн чиг үүрэг
- Тавигдах шаардлага
- Бүртгэх хугацаа
- Бүрдүүлэх материал
- Онлайнаар бүртгүүлэх
- Байгууллагын хаяг, утас, цахим шуудан
- Байгууллагын лого бүхий албан постер хэлбэрээр үг үсэг, найруулгын хувьд алдаагүй, товч бөгөөд тодорхой байна.

9.3 Иргэнийг төрийн албан тушаалд болон ажилд авахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

9.3.1 Ажилд орохыг хүсэгчийн өргөдөл

9.3.2 Төрийн албан хаагчийн анкет

9.3.3 Боловсрол, мэргэжлийн диплом, гэрчилгээ, сертификатын хуулбар

9.3.4 Иргэний үнэмлэхний хуулбар

9.3.5 Урьд ажиллаж байсан бол тухайн байгууллагаас ажил байдлын тодорхойлолт /шаардлагатай тохиолдолд/

9.3.6 Цээж зураг 4% /3\*4/

## АРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОГЧДЫН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ

10.1 Нэгдсэн эмнэлэгээс зарласан шинэ болон сул ажлын байранд энэхүү журмын 2.1 -д заагдсан бичиг баримтыг зар тавьсан өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор хүлээн авна.

10.2 Хугацаа хэтэрсэн тохиолдолд материалыг хүлээн авахгүй

10.3 Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй

### АРВАН НЭГ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11.1 Сонгон шалгаруулалтын 1 дүгээр шатыг хүний нөөц хөгжлийн алба зохион байгуулж , баримт бичиг ,шалгуур үзүүлэлтийг хангаж тэнцсэн иргэний материалыг эмнэлгийн захиралд танилцуулна.

11.2 Эмнэлгийн захиралд тэнцсэн иргэдээс мэдлэг, ур чадварын шалгалт авах товыг тогтооно.

11.3 Мэдлэг, ур чадварын шалгалтыг авах ажлын хэсэг нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

11.3.1Албадын дарга, тасгийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах ажлыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.1-д заасны дагуу зохион байгуулна.

11.3.2 Эмнэлгийн хүний их эмч , эм зүйч, нарыг сонгон шалгаруулах ажлын хэсэгт

Ахлагч : Хүний нөөц хөгжлийн алба

Гишүүд: Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба

Сургалт, судалгаа, соёл үйлчилгээ хамтын ажиллагааны алба

Ёс зүйн хэсгийн хороо

11.3.3 Арга зүйч, Сувилагч , эх баригч , эмнэлгийн тусгай мэргэжилтэнг сонгон шалгаруулах ажлын хэсэгт

Ахлагч : Хүний нөөцийн алба

Гишүүд : Сувилахуйн албаны алба

Сургалт, судалгаа, соёл үйлчилгээ хамтын ажиллагааны алба

Ёс зүйн хэсгийн хороо

11.3.4 Эмнэлгийн бус ажилчид нарыг сонгон шалгаруулах ажлын хэсэг

Ахлагч : Хүний нөөц хөгжлийн алба

Гишүүд: Эдийн засаг Төлөвлөлт, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал

Сургалт, судалгаа, соёл үйлчилгээ хамтын ажиллагааны алба

Халдвараас сэргийлэх хяналт, дархлаажуулалтын алба

Ёс зүйн хэсгийн хороо

Тавигдах шаардлага : Эмнэлгийн хүний их эмч , эм зүйч нарт

- Боловсрол: АУ дээд сургуулийн бакалавр , магистер
- Мэргэжил: Хүний их эмч
- Мэргэшил : Тухайн мэргэжилээр мэргэшин байх.
- Туршлага : Эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай бол давуу тал болно
- Ур чадвар : - Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй
  - хэрэглээний программ , интернет , дотоод сүлжээнд ажиллах
  - Статистик судалгаа , дүн шинжилгээ хийх
  - Багаар ажиллах
  - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг баримтлан ажиллах
  - Боловсон харилцаа , хувийн соёлтой байх

- Хууль эрх зүйн мэдлэгтэй байх

Тавигдах шаардлага : Арга зүйч, Сувилагч , эх баригч , эмнэлгийн тусгай мэргэжилтэн нарт

- Боловсрол: АУ-ны дээд сургуулийн бакалавр, диплом, тусгай мэргэжлийн үнэмлэх гэрчилгээ
- Мэргэжил: Сувилагч, эх баригч , эмнэлгийн тусгай мэргэжилтэн
- Мэргэшил : Үндсэн мэргэжилээр мэргэшсэн бол давуу тал болно.
- Туршлага : Эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай бол давуу тал болно.
- Ур чадвар : - Англи хэлний анхан шатны мэдлэгтэй
  - Хэрэглээний программ , интернет , дотоод сүлжээнд ажиллах
  - Судалгаа , дүн шинжилгээ хийх чадвартай байх
  - Багаар ажиллах
  - Ёс зүйг баримтлан ажиллах
  - Боловсон харилцаа , хувийн соёлтой байх
  - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх

Тавигдах шаардлага : Тасгийн эрхлэгч

- Боловсрол: АУ-ны их дээд сургуулийн бакалавр , түүнээс дээш
- Мэргэжил: Хүний их эмч
- Мэргэшил : Үндсэн мэргэжилээр мэргэшсэн байх.
- Туршлага : Нэгдсэн эмнэлэгт .... жил / ажилласан туршлагатай байх
- Ур чадвар : - Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй
  - хэрэглээний программ , интернет , дотоод сүлжээнд ажиллах
  - Статистик судалгаа , дүн шинжилгээ хийх
  - Багаар ажиллах , зохион байгуулах
  - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг баримтлан ажиллах
  - Боловсон харилцаа , хувийн соёлтой байх
  - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх

Тавигдах шаардлага : Албаны дарга

- Боловсрол: Их дээд сургуулийн бакалавр , түүнээс дээш
- Мэргэжил: Тухайн мэргэжлээр 3-5 ажилласан байх
- Мэргэшил : Удирдлага зохион байгуулалтын сургалтад хамрагдсан бол давуу тал болно.
- Туршлага : Улсад ажилласан туршлагатай бол давуу тал болно.
- Ур чадвар : - Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй
  - Монгол хэл бичгийн зөв бичих дүрэм албан бичиг найруулгын мэдлэгтэй байх
  - хэрэглээний программ , интернет , дотоод сүлжээнд ажиллах
  - Статистик судалгаа , дүн шинжилгээ хийх
  - Багаар ажиллах , зохион байгуулах
  - Ёс зүйг баримтлан ажиллах
  - Боловсон харилцаа , хувийн соёлтой байх
  - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх

11.4 Томилогдсон ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтанд оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно.

11.5 Иргэн шалгалтанд орохоор бүртгүүлэхдээ хуурамч материал бүрдүүлсэн , худал мэдүүлсэн нь шалгалтын явцад , эсхүл хожуу илэрсэн тохиолдолд тухайн иргэний шалгалтыг бүхэлд нь хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд үүнээс үүсэх хариуцлагыг иргэн өөрөө хүлээнэ.

## АРВАН ХОЁР. БУСАД

12.1 Ажил олгогчийн төлөөлөл нь ажил горилогчоос шан харамж авах, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл, тусламж, биет болон биет бус эд зүйлс авахыг хориглоно.

12.2 Монгол улсын үндсэн хуулийн яс үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.